



## НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 7/47

Улаанбаатар хот

### С. Нарантуяад сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалт, Газрын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 9.1.8.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлээгүй Сургалт судалгааны хэлтсийн Сургалт, судалгаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Самданшаравын Нарантуяад сахилгын сануулах шийтгэл ногдуулсугай.

2. Дээрх зөрчлийг давтан гаргуулахгүй байхыг нийт албан хаагчдад анхааруулж, тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Г. Гантүшиг/-д үүрэг болгосугай.

ДАРГА  П. БАТХҮЛЭГ

УХА0596 5131448  
1116128632